



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Их шүтээн цогцолборын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/1/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Дотоод хяналт	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
8. Аудитын илрүүлэлт.....	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022. 03. 15 № 113
танай _____-ны № _____-т

“ИХ ШҮТЭЭН ЦОГЦОЛБОР”
ОНӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МӨНХТОГОО ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Орхон аймгийн "Их шүтээн цогцолбор" нь бурхан багшийн сэрэг дүрийн сэргээн засварлах, гадна тохижилтын ажлыг хийхээр иргэд болон аж ахуйн нэгжүүдээс хандив тусламж хүссэн үйл ажиллагааг зохион байгуулж, байгууламжийн ойр орчмын гэрэлтүүлэг, явган замыг сайжруулахаар төсөл хөтөлбөрийг боловсруулан ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>172 417 382,29</u>	<u>178 600 464,18</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13 403 625,97	9 629 946,18
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	765 700,00	-
31110	Төгрөг	765 700,00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	12 637 925,97	9 629 946,18
3121	Төгрөг	12 637 925,97	9 629 946,18
31213	Арилжааны банк дахь харилцах	12 637 925,97	9 629 946,18
33	АВЛАГА	66 919 956,00	77 782 208,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	198 147,00	5 190 000,00
335	Бусад авлага	66 721 809,00	72 592 208,00
3351	Байгууллагаас авах авлага	66 721 809,00	72 592 208,00
34	УРЬДЧИЛГАА	1 645 490,32	-
3471	Урьдчилгаа тооцоо	1 645 490,32	-
34713	Цалингийн урьдчилгаа	1 645 490,32	-
35	БАРАА МАТЕРИАЛ	90 448 310,00	91 188 310,00
351	Түүхий эд материал	90 241 310,00	90 212 310,00
35110	Тусгай зориулалттай материал	90 241 310,00	90 212 310,00
354	Хангамжийн материал	207 000,00	976 000,00
35410	Бичиг хэргийн материал	22 000,00	22 000,00
35420	Аж ахуйн материал	185 000,00	954 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3 612 781 974,17</u>	<u>3 523 163 690,64</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3 612 781 974,17	3 523 163 690,64
392	Биет хөрөнгө	3 612 781 974,17	3 523 163 690,64
39201	Барилга, байгууламж, орон сууц	3 740 821 179,00	3 740 821 179,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(398 278 551,32)	(463 711 402,52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	4 859 500,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(407 456,25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52 492 567,00	52 492 567,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10 292 780,64)	(13 364 592,00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	256 554 689,00	256 554 689,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(28 515 128,87)	(54 080 793,59)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3 785 199 356,46</u>	<u>3 701 764 154,82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>197 911,00</u>	<u>821 962,76</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	197 911,00	821 962,76
413	Өглөг	197 911,00	821 962,76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	197 911,00	821 962,76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3 785 001 445,46</u>	<u>3 700 942 192,06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3 785 001 445,46	3 700 942 192,06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4 201 065 701,85	4 205 925 201,85
51101	Өмч: - төрийн	4 201 065 701,85	4 205 925 201,85
512	Хуримтлагдсан үр дүн	(416 064 256,39)	(504 983 009,79)

Орхон аймгийн Их шүтээн цогцолборын
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	(416 064 256,39)	(416 064 256,39)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(88 918 753,40)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3 785 199 356,46	3 701 764 154,82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	55 951 800,00	64 723 900,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76 400,00	64 723 900,00
120	Нийтлэг татварын бус орлого	76 400,00	64 723 900,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76 400,00	64 723 900,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76 400,00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	64 723 900,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	55 875 400,00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55 875 400,00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55 875 400,00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	138 842 812,95	153 437 163,08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138 842 812,95	153 437 163,08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138 242 812,95	152 817 163,08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38 884 525,00	40 366 885,00
210101	Үндсэн цалин	38 884 525,00	40 366 885,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4 860 565,65	5 236 989,55
210201	Тэтгэврийн даатгал	3 305 184,65	3 646 346,63
210202	Тэтгэмжийн даатгал	388 845,25	403 668,37
210203	ҮОМШӨ-ний даатгал	311 076,21	298 903,96
210204	Ажилгүйдлийн даатгал	77 769,04	80 733,79
210205	Эрүүл мэндийн даатгал	777 690,50	807 336,80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 101 380,00	8 037 615,00
210301	Гэрэл, цахилгаан	4 681 380,00	7 417 615,00
210303	Цэвэр, бохир ус	-	620 000,00
210304	Байрны түрээс	420 000,00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	855 000,00	687 250,00
210401	Бичиг хэрэг	165 400,00	253 850,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	208 000,00	185 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240 000,00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	241 600,00	248 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	277 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	277 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	516 280,00	3 533 640,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	-	3 105 000,00

Орхон аймгийн Их шүтээн цогцолборын
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392 000,00	392 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100 000,00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24 280,00	36 640,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88 025 062,30	94 677 783,53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250 000,00	200 000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87 775 062,30	94 477 783,53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600 000,00	620 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600 000,00	620 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600 000,00	620 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(82 891 012,95)	(88 713 263,08)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7 630 321,66	205 490,32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7 630 321,66	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	205 490,32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7 630 321,66)	(205 490,32)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(90 521 334,61)	(88 918 753,40)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4 201 065 701,85	-	(416 064 256,39)	3 785 001 445,46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	4 859 500,00	-	-	4 859 500,00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(88 918 753,40)	(88 918 753,40)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4 205 925 201,85	-	(504 983 009,79)	3 700 942 192,06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	68 930 867,00	64 723 900,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13 055 467,00	64 723 900,00
120	Нийтлэг татварын бус орлого	13 055 467,00	64 723 900,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13 055 467,00	64 723 900,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	411 400,00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	12 644 067,00	64 723 900,00

Орхон аймгийн Их шүтээн цогцолборын
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	55 875 400,00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55 875 400,00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55 875 400,00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	55 767 476,97	60 377 180,79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55 767 476,97	60 377 180,79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55 167 476,97	59 757 180,79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41 860 228,33	39 559 391,96
210101	Үндсэн цалин	40 530 228,33	39 559 391,96
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	1 330 000,00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4 860 588,64	5 222 283,83
210201	Тэтгэврийн даатгал	4 860 588,64	3 631 640,91
210202	Тэтгэмжийн даатгал	-	403 668,37
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	298 903,96
210204	Ажилгүйдлийн даатгал	-	80 733,79
210205	Эрүүл мэндийн даатгал	-	807 336,80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5 436 380,00	9 048 715,00
210301	Гэрэл, цахилгаан	4 681 380,00	8 403 715,00
210303	Цэвэр, бохир ус	-	645 000,00
210304	Байрны түрээс	755 000,00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	2 004 000,00	660 150,00
210401	Бичиг хэрэг	179 400,00	261 600,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	208 000,00	160 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 616 600,00	238 550,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	756 280,00	5 066 640,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	240 000,00	4 638 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392 000,00	392 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100 000,00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24 280,00	36 640,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250 000,00	200 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250 000,00	200 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600 000,00	620 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600 000,00	620 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600 000,00	620 000,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13 163 390,03	4 346 719,21
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	8 120 399,00
250006	Бусад зардал		8 120 399,00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	(8 120 399,00)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13 163 390,03	(3 773 679,79)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	240 235,94	13 403 625,97
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13 403 625,97	9 629 946,18

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Орхон аймгийн аялал жуулчлал амралтын “Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ нь “Бурхан багшийн сэрэг дүр”-ийг зураг төсвийн дагуу бүрэн дуусгаж, Орхон аймагтаа аялал жуулчлалыг төвлөрүүлэх томоохон цогцолборуудын нэг болгохыг зорин ажиллаж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус байгууллагын томилогдон ажиллаж байгаа удирдлагыг Орон нутгийн өмчийн газраас томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.2.2-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилох” гэсэн заалтыг үндэслэсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3.-д “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн тэтгэврийн даатгал-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, тэтгэврийн даатгал-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, шимтгэлийн дүн-ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, шимтгэлийн дүн-даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсөн.
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолд 2021 оны 207 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж 1 дэх заалтын “7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл” гэснийг “12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал” гэж өөрчилсөн.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,403.6	9,629.9	(3,773.7)
Авлага	66,920.0	77,782.2	10,862.2
Бараа материал	90,448.3	91,188.3	740.0
Үндсэн хөрөнгө	3,612,782.0	3,523,163.7	(89,618.3)
Нийт хөрөнгө	3,785,199.4	3,701,764.2	(83,435.2)
Өр төлбөр	197.9	822.0	624.1
Эздийн өмч	3,368,937.2	3,195,959.2	(172,978.0)
Хуримтлагдсан үр дүн	(416,064.3)	(504,983.0)	(88,918.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,785,199.4	3,701,764.2	(83,435.2)

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл кассанд байгаа бэлэн мөнгө 765.7 мянган төгрөг, банкин дахь мөнгө 12,637.9 мянган төгрөг байсан ба тайлант оны эцэст кассанд бэлэн мөнгөний үлдэгдэлгүй болж, банкин дахь мөнгө 9,629.9 мянган төгрөг болж нийт мөнгөн хөрөнгө маань 3,773.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл нь 77,782.2 мянган төгрөг болж өмнөх оноос 10,862.2 мянган төгрөгөөр өссөн нь бусад тооцооны авлага 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 4,129.6 авлага төлөгдсөн байна..

Бараа материалын дансны үлдэгдэл нь 91,188.3 мянган төгрөг болж өмнөх оноос 740.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 213.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1,413.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 959.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал худалдан авч, 213.1 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 644.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 988.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал зарлагдсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,523,163.7 мянган төгрөг болж өмнөх оноос 89,618.3 мянган төгрөгөөр буурсан нь Орхон аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4,859.4 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч машин тоног төхөөрөмж нэмэгдэж, тайлант хугацааны элэгдэл хорогдлоор буурсан байна.

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 197.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй байсан ба тайлант хугацаанд 624.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 821.9 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Хуримтлагдсан үр дүн тайлант онд 88,918.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт компанийн тайлант хугацаанд гарсан өртөг, зардлыг ашиглалт, засвар, үйлчилгээ, зардлын төвүүдэд аккруэл сууриар бодитой, үнэн зөв тооцож, тайлант хугацаанд нь

зохистой ангилж, хуваарилж бүртгэх, үйл ажиллагааны бусад зардлыг аккрузэл сууриар зөв, тооцож бүртгэхээр заасан байна.

3.4. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот гүйцэтгэл

Орхон аймгийн “Их шүтээн цогцолбор” нь бурхан багшийн сэрэг дүрийн сэргээн засварлах, гадна тохижилтын ажлыг хийхээр иргэд болон аж ахуйн нэгжүүдээс хандив тусламж хүссэн үйл ажиллагааг зохион байгуулж, байгууламжийн ойр орчмын гэрэлтүүлэг, явган замыг сайжруулахаар төсөл хөтөлбөрийг боловсруулан ажилласан байна.

“Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ нь Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанд тайлант хугацааны нийт зарлагыг 68,181.4 мянган төгрөгөөр тооцоолон хүргүүлсэн ба Эрдэнэт сангаас 64,723.9 мянган төгрөгөөр батлуулан авсан байна.

Тайлант онд 153,437.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган 88,713.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зардал, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

“Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн А/10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа боловч санхүүгийн программ нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Тайлант онд тус байгууллагын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл болон санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах байгууллагаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллага нь дотоод хяналтын ажлын хэсэг байгуулж ажилладаггүй ба захирал, менежер түүврээр анхан шатны баримтжуулалт, цалин бодолт зэргийг хянаж, тайланг хуулийн хугацаанд гаргаж хэвших талаар мэдээлэл хүргүүлж ажилладаг байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 64,724.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 647.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 453.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Их шүтээн цогцолбор” ОНӨҮГ нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 80,364.5 мянган төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулахаас, 3 мэдээ мэдээлэх хугацаа болоогүй, 5,556.5 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож, 74,808.0 мянган төгрөгийн 135 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй хуулийн хугацаанд мэдээллийг мэдээлээгүй ба анхан шатны баримтыг хүчин төгөлдөр баримтаар хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийт 29,561.7 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 20,540.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 9,021.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага	2	20,540.7	2	20,540.7			
Зөвлөмж	3	9,021.2	3	9,021.2			
Нийт дүн	5	29,561.9	5	29,561.9			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны эцэст үлдсэн өглөг авлагын үлдэгдлийг баталгаажуулж, тооцоо нийлсэн акт болон холбогдох эрх зүйн баримтыг тулган баталгаажуулах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 961.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 252.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 240.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага, 468.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 961.2 мянган төгрөгийн алдаа зөрчил нь 647.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан боловч, алдаа зөрчлүүдийн үзүүлэх нөлөөлөл бага тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд залруулага хийгдээгүй болно.

4.2 Албан шаардлага

1. Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй тайлангийн хугацаанд 240.0 мянган төгрөгийг баяр ёслолын арга хэмжээнд зарцуулсан тул албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансанд 7 мэдээлэл хоцроож Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтуудыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлсэн.

4.3 Төлбөрийн акт

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, и-баримтгүй 252.5 мянган төгрөг зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтанд түүнийг үлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн тул акт хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэсэн заалтыг баримталж ажиллаагүй, ажилчдын цалингаас хөнгөлөлтийг 22.0 мянган төгрөгөөр илүү, 2.0 мянган төгрөг дутуу тооцоолон тайлагнасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хуулийн дагуу эдлүүлж, жилийн эцэст тохируулга бичилт хийх.

2. Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж чөлөөлөгдөнө” гэж заасан ба дотоод журамд заагдсны дагуу ажилчдад олгож байгаа тэтгэмжүүд нь чөлөөлөлтөнд хамаарахгүй ба байгууллагаас олгосон 500.0 мянган төгрөгийн тусламж тэтгэмжээс 50.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган аваагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дотоод журамд заасан тэтгэмжүүдээс ХХОАТ суутган олгож байх.

3. Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Ажил гүйцэтгэх гэрээгээр ажилладаг үйлчлэгчийг сарын 250.0 мянган төгрөгөөр цалинжуулж ажлуулдаг ба нийт 12 сарын 3,050.0 мянган төгрөгийн цалингаас 366.3 мянган төгрөгийн нийгмийн даатгал, 28.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.2-д “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Гэрээгээр ажил гүйцэтгэгчийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож, нийгмийн даатгалын тайланд тайлагнах.

4. Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлангийн хугацааны эцэст 72,592.2 мянган төгрөгийн авлагийн үлдэгдэлтэй шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр төлөгдөж байгаа авлага байна. Мөн өмнөх онд биет бус хөрөнгө худалдан авсан 600.0 мянган төгрөгийн бичилтийг буруу хийж авлагаар тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Тайлант оны эцэст авлага, өглөг үүсгэхгүй байж, тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Их шүтээн цогцолбор	7	961.2			1	252.5	2	240.0	4	468.7
	Нийт дүн	7	961.2			1	252.5	2	240.0	4	468.7

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ийн ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

6117143690
ФАА0073 9042806